



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 12/04

Баянгол сум

┌ Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө ┐  
батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Зорилтот жил болгон зарлах тухай” 15/05 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд суманд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр танилцуулж үнэлэлт, дүгнэлт авч ажиллахыг сумын Засаг дарга (Д.Бямбатогтох)-д даалгасугай.



ДАРГА

Д.ЧИНЗОРИГ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн  
19/04 дүгээр тогтоолын хавсралт

“ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛТОТ ЖИЛИЙН  
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Ажил, арга хэмжээ	Шардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хугацаа	Хариуцах байгууллага
1. Удирдлага зохион байгуулалтын талаар				
1	Зорилтот жилийн ажлын хэсэг байгуулж, ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулна	Төсөв	1 дүгээр улиралд	ХААТ
2	“Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх жил”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах	Төсөв	1 дүгээр улиралд	ЗДТГ, ХААТ
3	Малчид, тариаланчид, хүнс үйлдвэрлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулна.	Төсөв	2 дугаар улиралд	ЗДТГ, ХААТ
4	Зорилтот жилийн хүрээнд “Болзолт уралдаан” зарлан, дүгнэж, урамшуулах	Төсөв	Жилдээ	ЗДТГ, ХААТ
5	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийг улс, бүс, орон нутгийн үзэсгэлэн худалдаанд нэгдсэн зохион байгуулалттай оролцуулах	Төсөв	Жилдээ	Ц.Лхамсүрэн
6	Бусад аймаг, сумдад газар тариалан, эрчимжсэн аж ахуй эрхлэх, хүсний үйлдвэрлэл, мал бордох, лабораторийн чиглэлээр тус тус туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах	Төсөв	2 дугаар улиралд	ЗДТГ
7	Малчдын малаа саах дадал хэвшлийг идэвхжүүлж, баг тус бүрээс уламжлалт аргаар сүү, цагаан идээ боловсруулан зах зээлд нийлүүлсэн малчин өрхийг шалгаруулах болзолт уралдаан зарлан урамшуулах, олон нийтэд сурталчлах	Төсөв	Жилдээ	ЗДТГ
8	“Намрын ногоон өдрүүд-2023” арга хэмжээг багуудын нэгдсэн өдөрлөг хэлбэрээр зохион байгуулах	Хандив	3 улиралд	ЗДТГ, ХААТ
9	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, сайн туршлага, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх	Төсөв	Жилдээ	ЗДТГ
10	Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж хагас, бүтэн жилээр үнэлүүлсэн байна.	-	Хагас, бүтэн жил	ЗДТГ



2. Малын гаралтай хүнсний түүхий эдийг нэмэгдүүлэх чиглэлээр

11	Нийт малчин өрхийн 10-аас доошгүй хувьд үрийн дэмжлэг үзүүлж, өвөлжөө хаваржаанд нь малын тэжээл тариалуулах	Төсөв	2-3 дугаар улиралд	А.Цэрэндорж Б.Учралт Багийн Засаг дарга нар
12	Сүү, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй байгуулахад хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамрагдах боломжийг бүрдүүлж, мэдээллээр хангах	Хоршоог хөгжүүлэх сан, ХЭДС	Жилдээ	А.Цэрэндорж Ц.Лхамсүрэн Багийн Засаг дарга нар
13	Баянгол омгийн хонийг үүлдэрээр баталгаажуулах судалгааны ажлын хүрээнд хаврын жигнэлт хийж хурганы төрөх үе, 6, 12, 18 сартай үеийн амьдын жин, биеийн хэмжээг тодорхойлох.	Төсөв	2 дугаар улиралд	А.Цэрэндорж Багийн Засаг дарга нар
14	Баянгол омгийн хонийг үүлдэрээр баталгаажуулах судалгааны ажлын хүрээнд Баянгол омгийн хонийг генетикийн шинжилгээнд хамруулах.	Төсөв	3 дугаар улиралд	ХААТ МАНЭШХ-ийн Генетикийн лаборатори Багийн Засаг дарга нар
15	Малын гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тарилга туулгад хамруулах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Төсөв	Жилдээ	ХААТ Мал эмнэлэг

3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр

16	Бага оврын усалгааны тоног төхөөрөмжийг шинээр нэмэгдүүлж, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 5-аас доошгүй гектараар нэмэгдүүлэх	Төсөв	2 дугаар улиралд	Б. Учралт
17	Жимс, жимсгэнэ тариалах иргэдэд сумаас суулгацын дэмжлэг үзүүлж тариалалтыг нэмэгдүүлэх	Төсөв	Жилдээ	Б. Учралт
18	Сумын хэмжээнд хүнсний ногооны тариалан эрхлэгчдэд үрийн дэмжлэг үзүүлэх	Төсөв	2 дугаар улиралд	Б. Учралт
19	Сумын хэмжээнд 20-с дээш өрхийг шинээр төмс, хүнсний ногооны тариалалт хийхэд үр болон технологи, арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Төсөв	Жилдээ	Б. Учралт
20	Тариаланчдад техник, тоног төхөөрөмж, гар багажийн дэмжлэг үзүүлэх	Төсөв	2-3 дугаар улиралд	Б. Учралт
21	Суманд хүлэмж болон нийлэг хальсны дэмжлэг үзүүлж, хүлэмжийн ногооны тариалалтыг нэмэгдүүлэх	Төсөв	2-3 дугаар улиралд	Б. Учралт
22	Сумын төмс, хүнсний ногооны зоорийг сэргээн засварлах, ашиглалтыг сайжруулах	Төсөв	Жилдээ	Б. Учралт
23	Атаршсан газрын ашиглалтыг сайжруулах	Төсөв	Жилдээ	Б. Учралт



24	Баянгол омгийн хонийг үүлдэрээр баталгаажуулах судалгааны ажлын хүрээнд бэлчээрийн бүтэц бүрэлдэхүүн, ургамалжилт судалгаа хийх.	Төсөв	3 дугаар улиралд	А.Цэрэндорж Б.Учрал, МАЗШХ-ийн Бэлчээр тэжээлийн салбар
<b>4. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын чиглэлээр</b>				
25	Мал нядалгааны цэгийн эрүүл ахуй, орчин нөхцөлийг сайжруулах	Төсөв	Жилдээ	ЗДТГ
26	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нийслэл Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлэх борлуулалтыг дэмжих сүлжээ бий болгох	Төсөв	Жилдээ	ЗДТГ
27	Суманд сүү, цагаан идээ, хүнсний ногоог борлуулах цэг бий болгох	Төсөв	Жилдээ	ЗДТГ
<b>5. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр</b>				
28	"Хүнсний зориулалтын бус савыг хүнсэнд хэрэглэхээс татгалзсан сум" хөдөлгөөн өрнүүлэх, малчдыг сүү цагаан идээгээ хүнсний зориулалтын саванд боловсруулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Төсөв	Жилдээ	Ц.Лхамсүрэн
29	Иргэдэд хоол, хүнсний аюулгүй байдал, зохистой хэрэглээний талаар сургалт сурталчилгаа, нөлөөлөх ажлыг зохион байгуулах (БИНХ)	Төсөв	Жилдээ	ЗДТГ, ЭМТ
30	Сургуулийн хүүхдийн дотуур байрны гал тогооны хоол үйлдвэрлэлийн хэсэгт засвар хийж эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх	ОНХС	Жилдээ	ЗДТГ, ЕБС
31	Хүнс үйлдвэрлэл болон худалдаа эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж, үйлчилгээний байгууллагуудад эрүүл ахуй, чанар аюулгүй байдалд сар бүр хяналт үнэлгээ хийх	Төсөв	Сар бүр	ЗДТГ
32	Бусад			